

## ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ БА ДАРААХ ӨРХИЙН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ

**Алгаагийн Солонго**<sup>1</sup>, доктор, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургуулийн профессор

**Мөнхбатын Баяржаргал**, магистр, Үндэсний Статистикийн Хороо, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар, Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

### Хураангуй

Эмзэг байдлыг эмпирик аргаар хэмжих, тоон үзүүлэлтээр тодорхойлох сонирхол судлаачдын дунд нэмэгдсээр байна. Бид цар тахлын өмнөх ба дараах Монгол Улсын өрхүүдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг харьцуулан үнэлэх зорилгоор энэхүү шинжилгээг хийсэн. Нийгмийн эмзэг байдлын индекс (SoVI) тооцох аргаар өрхийн түвшний эмзэг байдлыг үнэлэхдээ i) хүн ам зүйн шинж байдал, ii) өрхөд үзүүлж буй нийгмийн дэмжлэг, iii) өрхийн эдийн засгийн нөхцөл байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэмжигдэхүүнээр шинжилсэн. Шинжилгээнд ҮСХ-ны Өрхийн нийгэм, эдийн судалгааны 2018 он (n=16454), 2022 оны (n=22995) мэдээллийн баазыг ашигласан. Шинжилгээгээр өрхийн түвшний хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал цар тахлын өмнөх үетэй (HHVI=0.517) харьцуулахад цар тахлын дараа (HHVI=0.498) буурсан байна. Бүрэлдэхүүнээр задалбал, өрхийн хүн ам зүйн эмзэг байдал бага, харин нийгэм, эдийн засгийн эмзэг байдал өндөр байгаа ба энэ хандлага цар тахлын өмнөх болон дараах аль аль үед ижил байна. Цар тахлын дараа өрхийн нийгмийн эмзэг байдал нэмэгдэж, хүн ам зүйн болон эдийн засгийн эмзэг байдал буурсан байна. Өрхийн анхдагч нэгж дээр суурилан эмзэг байдлыг хэмжсэн явдал нь Ковид-19, зуд зэрэг нийтийг хамарсан цар тахал, байгалийн гамшигт үзэгдлийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх оновчтой хариу арга хэмжээ авахад эмпирик нотлох баримтыг бий болгох практик ач холбогдолтой болно.

**Түлхүүр үгс:** эмзэг байдал; өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдал

### DEMOGRAPHIC AND SOCIO-ECONOMIC VULNERABILITY OF HOUSEHOLDS PRE-AND-POST PANDEMIC

#### Abstract

There is a growing interest among researchers in empirically measuring and quantifying vulnerability. We conducted this analysis to compare demographic and socioeconomic vulnerability at the household level before and after the pandemic. Based on the Social Vulnerability Index (SoVI) calculation method, household-level vulnerability analysis was selected and analyzed using three components: demographic characteristics of the household, social support provided to the household, and economic condition of the household. In the analysis, the 2018 (n=16,454) and 2022 (n=22,995) databases of the 2018 (n=16,454) and 2022 (n=22,995) data were utilized. The analysis showed that household-level demographic and socio-economic composite vulnerability decreased after the pandemic (HHVI=0.498) compared to before the pandemic (HHVI=0.517). By composition, households exhibited low demographic vulnerability and high socio-economic vulnerability, and this trend persisted in both pre- and post-pandemic periods. After the pandemic, household social vulnerability increased while demographic and economic vulnerability decreased. Measuring vulnerability based on the primary household unit has practical implications for generating empirical evidence for optimal responses to threats from pandemics and natural disasters such as COVID-19 and measles.

**Keywords:** vulnerability; demographic and socio-economic vulnerability of household

## 1. ОРШИЛ

Эмзэг байдал гэдэг нь урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл юм. Сүүлийн жилүүдэд ядуурлыг бууруулах, байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх, зээлийн хөрөнгө оруулалтын төслүүдийн нийгэм, ядуурал, жендэрийн тэгш бус байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, иргэд,

<sup>1</sup> Холбоо барих зохиогч: Хаяг: solongo\_a@num.edu.mn

олон нийтийн гэнэтийн цочрол, эрсдэлийг даван туулах чадавхыг бий болгоход чиглэсэн олон улсын болон үндэсний бодлогын хэлэлцүүлэгт эмзэг байдлын шинжилгээг ихээхэн анхаарах болсон.

Макро түвшний үзүүлэлтүүдээс харахад Монгол Улсад ядуурлын түвшин цар тахлын өмнө буюу 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь, 2022 онд 27.1 хувь болж буурчээ (NSO, WB, 2022). Ази, Номхон далайн бүсийн дундажтай харьцуулахад Монгол Улсад ядуурлын бууралт удаан, ядуурлын түвшингээр 86 улсыг жагсаахад 52-т орж байна<sup>2</sup>. Ковид-19 цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ, хөтөлбөрүүд ядуурлын өсөлтийг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж ядуурлын тайланд дүгнэжээ (NSO, WB, 2022).

Эдийн засаг өсч цар тахлын өмнөх үеэс давсан (жилийн өсөлт 2019 онд 5.5%, 2022 онд 8.3% байсан)<sup>3</sup> хэдий ч нэг хүнд ногдох орлогын өсөлт<sup>4</sup> нь хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд дорвитой нөлөөлөхгүй байна. Хамгийн чинээлэг хэсгийн дундаж хэрэглээ хамгийн ядуу бүлгийнхээс 5.1 дахин их байгаа ба орлогын тэгш бус байдал нэмэгдсээр байна (NSO, WB, 2022).

Үүнээс гадна дэлхийн болон бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн давтамжийн өсөлт, бэлчээрийн даацаас хэтэрсэн мал сүргийн өсөлт, уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн өсөлт зэрэг нь үндэсний болон хувь хүний түвшинд эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр үзүүлж байна. Тухайлбал, Монгол Улсад 1944 оноос хойш 12 жил зуд болсон бөгөөд 2009-2010 оны зуднаар нийт малын 31.5 хувь нь хорогдож, малчдын гуравны нэг орчим нь орлогын гол эх үүсвэр болох малынхаа тал хувийг алдаж байв. Хөдөөд ядуурлын түвшин өндөр байгаа нь хүн ам хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөний бодит шалтгаан болж байна. Хүн ам зүйн энэхүү үзэгдлийн хариуд хотод усан хангамж, ариун цэврийн байгууламж, дулаан хангамж зэрэг суурь үйлчилгээний хүртээмж доголдож, эрчим хүчний хэрэглээ, агаар, хөрсний бохирдол нэмэгдэж, хотын эмзэг бүлгийн өрх, хүн амыг улам бүр доройтуулсаар байна. Алслагдсан хөдөө орон нутаг, хотын захын хороололд амьдардаг иргэд, өрхүүд ядуурал, эмзэг байдалд илүү өртөмтгий болсоор байна (Solongo, 2020).

Өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээг хийснээр өрхүүдийг аливаа сөрөг цочирлын улмаас ядууралд өртөх эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах ач холбогдолтой юм. Мөн эмзэг байдлын шинжилгээний үр дүнг иргэдийн аж байдлыг дээшлүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр төлөвлөх, төсөвлөх, хөрөнгийн хуваарилалтыг урьдчилан тодорхойлох зэрэгт ашиглах боломжтой. *Иймд*, цар тахлын өмнөх ба дараах өрхийн түвшний хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг харьцуулан үнэлэх *зорилгоор* энэхүү дүн шинжилгээг хийсэн болно.

## 2. СУДЛАГДСАН БАЙДАЛ: ОНОЛ, АРГА ЗҮЙ

Нийгэм судлаачид, эрдэмтэд эмзэг байдлыг ихэвчлэн тухайн системийн чадварыг тодорхойлдог нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн багц гэж үздэг (Aksha, Juran, Resler, & Y., 2019). Энэ утгаараа систем эсвэл популяцийн эмзэг байдал нь юун түрүүнд тухайн систем эсвэл хүн амтай холбоотой олон хүчин зүйлээр тодорхойлогддог (Wisner, 2013; Praveen, Yagawendra, Sandhya, Niharika, & J, 2020). Эдгээр хүчин зүйлсийг тухайн систем эсвэл хүн амын нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж чанаруудыг нэгтгэж, хүн амын цочролд өртөмтгий эсвэл мэдрэмтгий

<sup>2</sup> <https://wisevoter.com/country-rankings/poverty-rate-by-country/#mongolia>

<sup>3</sup> The World Bank. 2023. <https://www.macrotrends.net/countries/MNG/mongolia/gdp-per-capita>

<sup>4</sup> Мөн дээрхид. Нэг хүнд ногдох ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 онд 4,395 ам доллар, 2022 онд 4,947 ам.доллар байсан.

байдал, стрессийг даван туулах чадвар зэрэг олон талтайгаар авч үзэх шаардлагатай (Sigridur, Yue, & Mark, 2011; Wisner, 2013).

Нийгэм, эдийн засгийн эмзэг байдал нь бусад төрлийн эмзэг байдлаас илүү хувь хүн, олон нийтийг цочролд өртөхөд гол үүрэг гүйцэтгэдэг гэдгийг олон судлаачид хүлээн зөвшөөрсөн байна (Wisner, 2013; Praveen, Yarawendra, Sandhya, Niharika, & J, 2020; Negusie, 2022; Phuong, Huynh, Thu, & Bui, 2024). Тиймээс өрхийн түвшинд эмзэг байдлын дүн шинжилгээ хийх, бодит нөлөөллийг даван туулах стратеги арга замыг тодорхойлох, Ковид-19 зэрэг гэнэтийн цочрол, эрсдэлийн нөлөөг үнэлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн хэмжүүрүүдээр эмзэг байдлын шинжилгээ хийх асуудалд олон судлаачид анхаарал хандуулж байна (Praveen, Yarawendra, Sandhya, Niharika, & J, 2020; Phuong, Huynh, Thu, & Bui, 2024). Тухайлбал, Ковид-19 цар тахлын улмаас орлого нь мэдэгдэхүйц буурсан, нийгэм-хүн ам зүйн байдал доогуур байгаа, түүний дотор ахмад настай фермерүүдтэй, орлогын эх үүсвэр багатай, хөдөөгийн өрхүүд сөрөг нөлөөнд илүү өртөмтгий байсныг Praveen нар (2020) нотолжээ. Мөн тэд өрхийн түвшний нийгэм, эдийн засгийн хэмжигдэхүүнд үндэслэн нийгэм, эдийн засгийн түвшин доогуур өрхүүд нийгэм, эдийн засгийн өндөр статустай өрхүүдээс илүү эмзэг бөгөөд ядууралд өртөх магадлал өндөр байсныг илрүүлсэн байна.

Эмзэг байдлыг эмпирик аргаар хэмжих, тоон үзүүлэлтээр тодорхойлох сонирхол судлаачдын дунд нэмэгдсээр байна. Нийгмийн эмзэг байдлыг үнэлэх нийтлэг арга бол нийгмийн үзүүлэлтүүдийг нэгтгэсэн индекс (Cutter, S.L., Boruff, B.J., & Shirley, W.L., 2003; Yi, Zhang, Ge, & Zhao, 2014; Praveen, Yarawendra, Sandhya, Niharika, & J, 2020; Negusie, 2022; Phuong, Huynh, Thu, & Bui, 2024) бөгөөд сүүлийн үеийн судалгаануудад Wisner (2013) нарын боловсруулсан “Нийгмийн эмзэг байдлын индекс-SoVI” нэлээд түгээмэл ашиглагдсан байна. Энэ индексийг тооцоход анхдагч мэдээлэлд суурилсан үзүүлэлтүүдийг ашигладаг бөгөөд тооцоог эмзэг бүлгийн хүн ам, бүс нутагт үзүүлэх дэмжлэгт анхаарахад хэрэглэж байна (Wisner, 2013). Нийгмийн эмзэг байдлын индекс нь цаг хугацааны явцад улам боловсронгуй болж, янз бүрийн бүс нутаг, нийгмийн нөхцөл байдалд өргөн хэрэглэгдэж ирсэн байна. Тухайлбал, байгаль орчны эмзэг байдлын нөлөөллийн үнэлгээнд төдийгүй, Ковид-19 цар тахал зэрэг гэнэтийн цочрол, эрсдэлтэй холбоотой судалгаануудад SoVI аргыг хувь хүн, олон нийт, бүс нутгийн нийгэм, хүн ам зүйн эмзэг байдлыг хэмжихэд ашиглаж байна.

### 3. АРГА ЗҮЙ

Монгол Улсын өрхүүдийн хувьд эмзэг байдлыг судлахдаа нийгмийн эмзэг байдлын индекс (SoVI) тооцож буй олон улсын аргачлалыг ашигласан. Өрхийн түвшний эмзэг байдлын шинжилгээний хүрээг гаргахдаа Phuong нар (2024)-ын судалгаандаа хэрэглэсэнчлэн 1) өрхийн хүн ам зүйн шинж байдал, 2) өрхөд үзүүлж буй нийгмийн чадавх ба дэмжлэг, 3) өрхийн эдийн засгийн нөхцөл байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэмжүүрээр тогтоосон (Phuong, Huynh, Thu, & Bui, 2024). Бүрэлдэхүүн хэмжүүр бүрт хамаарах өрхийн түвшний үзүүлэлтүүд, тэдгээр үзүүлэлтүүд өрхийн эмзэг байдалтай ямар уялдаа хамааралтай байх талаарх таамаглалыг Хүснэгт 1-д товч тайлбарлав.

**Хүснэгт 1: Өрхийн эмзэг байдлын бүрэлдэхүүн хэмжүүрүүд, үзүүлэлтүүд ба таамаглал**

Бүрэлдэхүүн хэмжүүр	Үзүүлэлт (n)	Нэгж	Сонгосон үзүүлэлт ба эмзэг байдлын хамаарал (таамаглал)
1. Хүн ам зүйн шинж байдал	1.1.Өрхийн тэргүүлэгчийн нас	жил	Нас ахих тусам илүү мэдрэмтгий, хямрал, цочролд хариу үйлдэл бага хийдэг. (+)
	1.2.Амын бүлийн тоо	тоо	Олон ам бүлтэй өрх хямрал, цочролд илүү эмзэг байдаг. (+)
	1.3.Өрхийн хүүхэд, өндөр настай гишүүдийн тоо	тоо	Өрхөд хүүхэд, өндөр настан буюу хамаарал ихтэй гишүүн олон байх тусам илүү эмзэг байдаг. (+)
2. Нийгмийн чадавх, дэмжлэг	2.1.Өрхийн тэргүүний боловсрол	түвшин	Боловсрол нь хүмүүсийг илүү ухамсартай болгож, хямрал, цочролд хариу үйлдэл илүү сайн хийх чадвартай болгодог. (-)
	2.2.Хамаатай садан, найз нөхдөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	1=тийм 0=үгүй	Дэмжлэг авч чаддаг өрхүүд хямрал, цочролыг илүү сайн даван туулж чадна. (-)
	2.3.Төрөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	1=тийм 0=үгүй	Дэмжлэг авч чаддаг өрхүүд хямрал, цочролыг илүү сайн даван туулж чадна. (-)
	2.4.Байгууллага, олон нийт, иргэний нийгмийн байгууллагаас тусламж дэмжлэг авдаг эсэх	1=тийм 0=үгүй	Дэмжлэг авч чаддаг өрхүүд хямрал, цочролыг илүү сайн даван туулж чадна. (-)
3. Эдийн засгийн нөхцөл байдал	3.1.Төрийн байгууллагад ажилладаг өрхийн гишүүн байдаг эсэх	1=тийм 0=үгүй	Төрийн байгууллагад ажил эрхлэгчийн цалин, орлого хямрал, цочролын үед тогтвортой байдаг. (-)
	3.2.Өрх хадгаламж, хуримтлалтай эсэх	1=тийм 0=үгүй	Хадгаламж, хуримтлалтай өрх хямрал, цочролыг илүү сайн даван туулж чадна. (-)
	3.3.Орлогын эх үүсвэрийн тоо	тоо	Орлогын эх үүсвэр олон янз байх нь хямрал, цочролын үед өрхийн амьжиргааны дасан зохицох чадварыг нэмэгдүүлдэг. (+)

Эх үүсвэр: Phuong T.A et al., 2024.

Өрхийн эмзэг байдлыг тооцоход, *эхний шатанд* өөр өөр нэгжээр хэмжигддэг үзүүлэлтүүдийг 0-ээс 1 хооронд байх тодорхой нэгжгүй ижил хэмжүүр индекс болгон хувиргасан. Уг хувиргалтыг хийхдээ 10 үзүүлэлт бүрийн хувьд: судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд ажиглагдсан хамгийн өндөр ( $S_{max}$ ) болон хамгийн бага ( $S_{min}$ ) утга, мөн тухайн өрхийн ажиглалтын утга ( $S_i$  болон  $S_x$ ) гэсэн мэдээллүүдийг ашиглан [1], [2] томъёонуудаар тооцсон. Хэрэв, тухайн үзүүлэлт өрхийн эмзэг байдалтай эерэг (+) хамааралтай гэж үзвэл *Index  $S_i$* , харин сөрөг (-) хамааралтай гэж үзвэл *Index  $S_x$*  томъёог ашигласан. Үүнд:

$$Index S_i = \frac{S_i - S_{min}}{S_{max} - S_{min}} \quad [1]$$

$$Index S_x = \frac{S_{max} - S_x}{S_{max} - S_{min}} \quad [2]$$

Индекс нь 0-ээс 1 хооронд ( $1 \leq HHVI \leq 0$ ) утга авах боломжтой ба 0 утга нь тухайн үзүүлэлтээр өрхүүд эмзэг байдалд өртөөгүйг, 1 утга нь тухайн үзүүлэлтээр өрхүүдийн эмзэг байдал байж болох хамгийн өндөр түвшинд буйг илтгэнэ. Сонгосон үзүүлэлт бүрийн хувьд ажиглагдсан хамгийн өндөр, хамгийн бага утгуудыг Хавсралтаас харна уу.

Тооцооллын хоёрдугаар шатанд, өрхийн хүн ам зүйн эмзэг байдал, нийгмийн эмзэг байдал, эдийн засгийн эмзэг байдлын бүрэлдэхүүн индекс ( $CO_{index}$ )-үүдийг тооцохдоо, бүрэлдэхүүн тус бүрт орсон индексэн үзүүлэлтүүд ( $n=k$ ) адил тэнцүү ач холбогдолтой гэж үзэн ижил жин өгч, арифметикийн энгийн дунджийн аргаар буюу [3] томъёогоор тооцсон.

$$CO_{index} = \frac{\sum_{k=1}^n (SIS)k}{k} \quad [3]$$

Эцэст нь, 3 бүрэлдэхүүн индексээр өрхийн түвшний эмзэг байдлын нийлмэл индекс ( $HHVI$ ) тооцсон ба дээрхтэй ижил арифметикийн энгийн дунджийн арга ашигласан [4].

$$HHVI = \frac{\sum_{n=1}^3 CO_{index}}{3} \quad [4]$$

Шинжилгээнд Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ноос 2018 ба 2022 онуудад зохион байгуулсан Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны мэдээллийн баазыг ашигласан. Эдгээр нь үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий магадлалт түүврийн аргаар хийгдсэн судалгаа ба 2018 онд нийт 16,454 өрх, 2022 онд 22,995 өрх хамрагдсан байна. Бидний тооцоололд эдгээр бүх өрхийн мэдээлэл бүрэн ашиглагдсан болно.

Шинжилгээний хязгаарлагдмал байдлын хувьд, энэ удаагийн ажилд хүн ам зүйн гол судлагдахуунуудын нэг болох өрхийн гишүүдийн эрүүл мэнд, өвчлөлийн хэмжүүрийг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн тоог шинжилгээнд ашиглаж чадаагүй. Иймд, цаашид өрхийн хүн ам зүйн эмзэг байдлын индексийн бүрэлдэхүүнд энэ үзүүлэлтийг нэмж оруулан шинжилгээг илүү нарийвчлах хэрэгцээ байгаа. Мөн өрхийн нийгмийн чадавхийг төлөөлөх хувьсагчдын нэгээр өрхийн тэргүүний боловсролыг сонгосон ба хэмжигдэхүүнийг “боловсролын түвшин” гэсэн дараалсан хэмжигдэхүүнээр авсан нь хангалтгүй юм. Дэлхий дахинаа хүн амын боловсролын түвшинг “сургуульд суралцсан дундаж хугацаа”-гаар тодорхойлж, боловсролын хүртээмж, чанарт илүү ач холбогдол өгдөг болсон. Иймээс ҮСХ-ноос 2022 оны ӨНЭЗС-гаар өрхийн гишүүдийн сургуульд суралцсан дундаж хугацааны талаар мэдээллийг цуглуулсан ч 2018 оны судалгаанд боловсролын мэдээллийг өөр хэмжигдэхүүнтэйгээр асууж мэдээлэл цуглуулсан байна. Иймд энэ удаагийн судалгаанд харьцуулагдах боломж бүрдүүлэхийн тулд өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин гэсэн хэмжүүрийг ашигласан. Цаашид өрхийн гишүүдийн боловсролд хамрагдсан хугацааны мэдээллээр индексийн тооцоог дахин хийж ашиглах нь дэлхий нийтийн хандлагатай нийцтэй байх болно.


## 4. ҮР ДҮН БА ХЭЛЦЭМЖ

### 4.1. Өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал

Энэхүү шинжилгээгээр Монгол Улсын өрхийн түвшний хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал цар тахлын өмнөх үе ( $HHVI=0.517$ )-тэй харьцуулахад цар тахлын дараа ( $HHVI=0.498$ ) буурсан байна. Энэ үр дүн ҮСХ, Дэлхийн банкны тооцоолсон ядуурлын түвшин цар тахлын өмнөх үеэс буурсан гэсэн үр дүнг дэмжиж байна.

Өрхийн нийлмэл эмзэг байдлын индексийг гурван бүрэлдэхүүнээр задалбал, өрхийн хүн ам зүйн эмзэг байдал бага, харин нийгмийн ба эдийн засгийн эмзэг байдал өндөр байгаа бөгөөд энэ хандлага цар тахлын өмнөх болон дараах үед ижил байна (Зураг 1).


Зураг 1: Өрхийн нийлмэл эмзэг байдлын бүрэлдэхүүн индексүүд, 2018 ба 2022 он



Гэхдээ хугацааны хувьд харьцуулахад цар тахлын дараа өрхийн нийгмийн эмзэг байдал нэмэгдэж (0.606-аас 0.648 болсон), хүн ам зүйн эмзэг байдал (0.322-аас 0.296) болон эдийн засгийн эмзэг байдал (0.623-аас 0.549) буурсан байна.

Цар тахлаас хойш өрхийн эмзэг байдлын бүрэлдэхүүн хэмжигдэхүүний үзүүлэлт бүрт гарсан өөрчлөлтийг Зураг 2-т харуулсан ба үр дүнг өгүүллийн 4.2, 4.3, 4.4 хэсгүүдэд тайлбарлав.

Зураг 2: Өрхийн эмзэг байдлын үзүүлэлт бүрт гарсан өөрчлөлт, 2018 ба 2022 он



#### 4.2. Өрхийн хүн ам зүйн эмзэг байдал

Өрхийн тэргүүний нас, ам бүлийн тоо, өрхийн гишүүдийн насны бүтэц (хүүхэд болон өндөр настны тоо) зэрэг өрхийн хүн ам зүйн шинж байдал цар тахлын өмнө ба дараа ойролцоо байгаа бөгөөд аль аль үед өрхийн хүн ам зүйн эмзэг байдал бага (0.101-ээс 0.388) байна (Зураг 2).

Үндэсний цаг ашиглалтын судалгаа (NSO, 2019)-аар өрхийн гишүүдийн насны бүтэц, эрүүл мэндийн байдлаас хамааран хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй зэрэг асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдэд зарцуулж буй хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүдийн

зарцуулдаг цаг эрэгтэйчүүдийнхээс 2.1 дахин их; тухайн өрхөд 16 хүртэлх насны хүүхдийн тоо нэмэгдэхийн хэрээр энэ цаг илүү нэмэгддэг; хүүхэд өвдсөн тохиолдолд даруй 10 дахин нэмэгддэг болохыг тогтоосон байдаг. Хэдийгээр бид шинжилгээндээ өрхийн гишүүдийн “хүйс”-ийн үзүүлэлтийг ашиглаагүй боловч гэнэтийн цочрол, хямрал тохиолдоход өрхийн эмэгтэйчүүд, ялангуяа өрх толгойлсон ээжүүд цагийн ядууралд<sup>5</sup> илүү өртөмтгий байгааг дээрх судалгааны үр дүн илтгэж байгаа юм.

Цар тахлын үеийн эмзэг байдлын шуурхай үнэлгээ (UNDP, 2020)-гээр, цар тахлын хөл хорионы үеэр хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өсч, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн дутагдалд хүүхдүүд хамгийн ихээр өртсөн байна. Сургууль, цэцэрлэгүүд хаагдсаны улмаас ихэнх хүүхдүүд өдрийн хоолоо гэртээ идэх болсноор цэцэрлэгийн болон бага ангид суралцдаг хүүхэдтэй өрхүүдийн хоол хүнсний зардал 8.6 хувиар өссөн гэжээ. Ядуу өрхийн хүүхдүүд цэцэрлэг, сургууль дээрээ тогтмол хэрэглэж чадаж байсан өдрийн хоолоо гэртээ идэх боломжгүй болсон байна. Өрхийн эрүүл мэндийн зардал нэмэгдэж, нийт өрхийн 27 орчим хувийн хүнсний хэрэглээ буурсан байна. Эндээс өрхийн ам бүлийн тоо, насны бүтэц зэрэг нь гишүүдийн эрүүл мэндийн байдал, хоол тэжээлийн хомсдол, өрхийн хэрэглээнд нөлөөлж, улмаар өрхийн эмзэг байдлыг өсгөх үндэс гэдгийг харж болно.

### 4.3. Өрхийн нийгмийн эмзэг байдал

Цар тахлын өмнөх үед 0.606 байсан өрхийн нийгмийн эмзэг байдал цар тахлын дараах үед 0.648 болж нэмэгдсэн байна. Үүнийг үзүүлэлтүүдээр нь задалж харвал, цар тахлын өмнөх үетэй харьцуулахад цар тахлын дараах үед өрхийн тэргүүний боловсролын түвшний эмзэг байдал 0.605-аас 0.548 болж буурсан байна (Зураг 2). Гэхдээ бид өрхийн гишүүдийн ялангуяа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн боловсролын эмзэг байдалд илүү анхаарах нь чухал гэдгийн дүн шинжилгээний хязгаарлагдмал байдалд тэмдэглэсэн билээ. НҮБ-ын Хүүхдийн Сан, ҮСХ-ноос хийсэн судалгаа (UNICEF, NSO, 2021)-гаар, цар тахлын үед цэцэрлэг, сургууль хаагдахад ядуу өрхийн 2-5 насны хүүхдүүдийн 58 орчим хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан бол чинээлэг өрхийн энэ насны хүүхдүүд бараг бүгд (94 хувь) хамрагдаж байжээ. Түүнчлэн, зайн сургалт нь боловсролын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх арга хэмжээ болсон хэдий ч эмзэг бүлэгт, ялангуяа цахим төхөөрөмж, ухаалаг гар утас, компьютер, интернет холболт байхгүй, цахилгаанд холбогдоогүй зэрэг хамгийн эмзэг бүлгийн болон хөдөө орон нутгийн хүүхэд, залуучуудад хүртээмж муутай байсны улмаас боловсролын тэгш бус байдлыг бий болгоход нөлөөлсөн гэж болно. Ийнхүү боловсрол дахь тэгш бус байдал нэмэгдэх нь өрхийн төдийгүй нийгмийн эмзэг байдал, ядуурлын учир шалтгаан гэж ойлгож болох юм.

Бидний хийсэн шинжилгээгээр, өрхөд төрөөс тусламж дэмжлэг үзүүлэхтэй холбоотой нийгмийн эмзэг байдал цар тахлын үеэс хойш нэмэгдсэн (0.001-0.087) байна (Зураг 2). Монгол Улсын Засгийн газраас эмзэг бүлгийн нийгмийн хамгааллын хөтөлбөр, түүнд зарцуулах хэмжээг нэмэгдүүлэх яаралтай арга хэмжээг цар тахлын үед авч, 2020 оны 4 сараас нэг хүүхэд сард олгох мөнгөний хэмжээг 20,000 төгрөгөөс 100,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Судлаач Людовико, Амартүвшин (2020) нар цар тахлын үед ядуу өрхүүдийн 80 орчим хувь нь хүүхдийн мөнгө хүлээн авсан ба тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн явдал тахлын өмнөх үеийн өрхийн орлогын бараг 40 хувьтай тэнцэхүйц, үр ашигтай байсан гэж тооцоолсон байна (Ludovico С., Amartuvshin Ts., 2020). Энэ нь олон хүүхэдтэй болон эмзэг бүлгийн өрхүүд гэнэтийн цочролыг даван туулахад бодит дэмжлэг болсон төдийгүй одоог хүртэл үргэлжилж, нийгмийн дэмжлэгээс хүртэж буй хүртээмжийг илтгэж буй чухал арга хэмжээ хэвээр байна.

<sup>5</sup> Цагийн ядуурал гэдэг нь тухайн хүн өөрт хэрэгтэй, хийхийг хүссэн бүх зүйлээ хийхэд хангалттай цаг байхгүй нөхцөл байдлыг хэлдэг. Энэ үзэгдэл нь зөвхөн завгүй байх тухай ойлголт биш юм. Энэ нь ажил болон хувийн амьдрал, хобби, амралтын хооронд байнгын ачаалалтай байх бөгөөд ихэвчлэн стресс, ядрахад хүргэдэг.

Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад цар тахлын дараах үед өрхөд үзүүлэх хувь хүний дэмжлэг туслалцаагаар хэмжигдэх нийгмийн эмзэг байдал бага зэрэг буурсан (0.943-0.866) бол байгууллагаас (олон нийтийн байгууллага ороод) авах дэмжлэг туслалцаагаар хэмжигдэх эмзэг байдал нэмэгдсэн (0.874-0.991) байна. *Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн* судалгаагаар, судалгаанд хамрагдсан нийт өрхийн (n=1500) бараг гуравны хоёр нь өдөр тутмын амьдралдаа өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхнээс тусламж, дэмжлэг авдаг бөгөөд өрхөд дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо өрхийн амьжиргааны бүлэг дээшлэх тутам нэмэгдэж байсан байна (UNDP, PTRC, 2004). Ийнхүү өрх болон өрхөд амьдарч буй хүмүүсийн дотно танил, хүрээллийнхний хоорондын холбоо, харилцаа нь бодитой оршиж, өрхийн амьжиргаанд тус дэм үзүүлсээр байгаа ч цар тахлаас хойш арай багасч, эсрэгээр төрийн ба байгууллагын тусламжаас хамаарах эмзэг байдал нэмэгдсэн байна.

#### 4.4. Өрхийн эдийн засгийн эмзэг байдал

Эрхэлж буй ажил тогтворгүй, цалин хөлс найдваргүй байх нь өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Монгол Улсад илүү тогтвортой, найдвартай ажлын байрыг хувийн хэвшилтэй харьцуулахад төрийн байгууллага илүү хангаж байгаа юм. Энэ удаагийн шинжилгээгээр өрхийн гишүүн төрийн байгууллагад ажил эрхэлдэг байх нь өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг нэлээд бууруулсан (0.951-аас 0.786) үр дүн гарлаа (Зураг 2).

Монгол Улсын Засгийн газраас цар тахлын эсрэг яаралтай хариу арга хэмжээний хүрээнд эмзэг бүлгийн бизнесийг дэмжих, урамшуулах, жижиг, дунд үйлдвэрлэлүүдийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) болон нийгмийн даатгалын шимтгэл (НДШ)-ээс чөлөөлөх арга хэмжээг авсан байна. Татварын энэхүү чөлөөлөлтүүд нь хувийн хэвшлийнхэнд ажилчдынхаа цалинг тасралтгүй олгох, үйл ажиллагааныхаа зардлыг санхүүжүүлэх, бизнесээ боломжоороо үргэлжлүүлэхэд үр нөлөөтэй байсан ба НДШ-ийн чөлөөлөлт нь ААНОАТ-ийн чөлөөлөлтөөс илүү эерэг нөлөө үзүүлсэн байна (Ludovico C., Amartuvshin Ts., 2020). Гэсэн хэдий ч цар тахлын улмаас нийтийн үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа зэрэг эмэгтэйчүүд зонхилон ажилладаг салбарууд хамгийн их хохирол амссан байдаг (UNDP, 2021).

Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад дараах үед хуримтлал, хадгаламжтай өрхийн эдийн засгийн эмзэг байдал бага зэрэг буурсан (0.752-оос 0.684) байна. Цар тахал, инфляц, байгалийн гамшгийн уршгаар ядууралд өртсөн хүмүүс хамгийн хямд, чанар муутай, илчлэг ихтэй хоол хүнс хэрэглэж, ерөнхийдөө бага идэхийн зэрэгцээ шим тэжээл багатай хоол хүнс хэрэглэдэг. Цаашилбал, урт хугацааны туршид өрхийн гишүүд шим тэжээлийн дутагдалд орж, хүнсний бүтээгдэхүүний зардал нэмэгдэхийн хэрээр биет хөрөнгөө зарах эсвэл өр зээлээс хамааралтай болдог. Иймд өрхийн хуримтлал, хадгаламж нь гэнэтийн цочрол, эрсдэл, эмзэг байдлыг даван туулах өрхийн санхүүгийн чухал нөөц юм.

Өрхийн орлого олон төрлийн эх үүсвэртэй байх нь өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг бууруулж чадахгүй байгааг (0.167-0.177) бидний шинжилгээний үр дүн илтгэж байна. Монгол Улсын Засгийн газраас 2016 оноос хэрэгжүүлж буй хүнсний эрхийн бичиг хөтөлбөр нь ядуу өрхөд тусгайлан анхаарсан цорын ганц хөтөлбөр бөгөөд хамрагдалтын хүрээ бага боловч үнийн өсөлт, зах зээлийн хямрал, цар тахлын эмзэг байдлыг бууруулахад ядуу, эмзэг өрхүүдэд хамгийн үр нөлөөтэй байсан гэдгийг судлаачид нотолсон байна (Ludovico C., Amartuvshin Ts., 2020).



#### 4.5. Өрхийн эмзэг байдлын байршлаарх ялгаа

Өрхийн түвшний хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдал нь цар тахлын өмнөх үетэй харьцуулахад цар тахлын дараа хот-хөдөө, бүс нутаг, өрхийн байршлаар нэлээд ялгаатай болсон байна (Хүснэгт 2). Тодруулбал, 2022 онд хотын өрхтэй (0.485) харьцуулахад хөдөөгийн өрхийн (0.513), Улаанбаатарын өрхүүдтэй (0.479) харьцуулахад бусад бүсийн өрхийн (0.500-0.506), байршлаар нийслэл (0.479), аймгийн төв (0.489), сумын төв (0.496)-ийн өрхтэй харьцуулахад хөдөөгийн багийн өрхүүдийн (0.533) хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал өндөр байна. Түүнчлэн эдгээр үзүүлэлт бүх байршилд цар тахлын өмнөх үеэс буурсан байгаа ч хөдөөд хамгийн бага буурчээ.

**Хүснэгт 2: Өрхийн түвшний эмзэг байдлын нийлмэл индекс, байршлын үзүүлэлтүүдээр**

Сонгосон үзүүлэлт	Цар тахлын өмнөх үе (2018 он)				Цар тахлын дараах үе (2022 он)			
	Бүрэлдэхүүн индексүүд			Эмзэг байдлын нийлмэл индекс	Бүрэлдэхүүн индексүүд			Эмзэг байдлын нийлмэл индекс
	DVI	SVI	EVI		DVI	SVI	EVI	
Үндэсний хэмжээнд	0.322	0.606	0.623	0.517	0.296	0.648	0.549	0.498
<b>Хот хөдөө</b>								
Хот	0.308	0.599	0.626	0.511	0.283	0.633	0.539	0.485
Хөдөө	0.338	0.614	0.619	0.524	0.312	0.665	0.561	0.513
<b>Бүс нутаг</b>								
Баруун	0.343	0.604	0.627	0.525	0.318	0.641	0.550	0.503
Хангай	0.328	0.616	0.628	0.524	0.304	0.654	0.559	0.506
Төв	0.316	0.603	0.610	0.510	0.289	0.659	0.552	0.500
Зүүн	0.329	0.601	0.602	0.511	0.302	0.653	0.551	0.502
Улаанбаатар	0.299	0.602	0.639	0.513	0.273	0.633	0.531	0.479
<b>Байршил</b>								
Нийслэл	0.299	0.602	0.639	0.513	0.273	0.633	0.531	0.479
Аймгийн төв	0.315	0.597	0.618	0.510	0.290	0.633	0.544	0.489
Сумын төв	0.325	0.610	0.610	0.515	0.299	0.655	0.535	0.496
Хөдөөгийн баг	0.354	0.620	0.629	0.535	0.329	0.678	0.592	0.533

Тайлбар: DVI-Өрхийн хүн ам зүйн эмзэг байдлын индекс  
SVI-Өрхийн нийгмийн эмзэг байдлын индекс  
EVI-Өрхийн эдийн засгийн эмзэг байдлын индекс

#### 5. ДҮГНЭЛТ

21-р зууны эхэн үеэс нийгмийн эмзэг байдлыг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж чанаруудыг нэгтгэж, хүн амын цочролд өртөмтгий эсвэл мэдрэмтгий байдал, стрессийг даван туулах чадвар зэрэг олон талтайгаар авч үзэхэд ихээхэн анхаарч, эмзэг байдлыг эмпирик аргаар хэмжих, тоон үзүүлэлтээр тодорхойлох сонирхол судлаачдын дунд нэмэгдсээр байна. Энэ зорилгоор нийгмийн эмзэг байдлын индексийг олон судлаачид ашиглаж байгаа бөгөөд цаг хугацааны явцад улам бүр боловсронгуй болж, өөр өөр бүс нутаг, нийгмийн нөхцөл байдалд янз бүрийн түвшинд өргөн хэрэглэгдэж иржээ.

Бидний тооцооллоор Монгол Улсын өрхийн түвшний хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал цар тахлын өмнөх үе (2018 он)-тэй харьцуулахад цар тахлын дараа (2022 он) буурсан байна. Энэ үр дүн ҮСХ, Дэлхийн банкны тооцоолсон ядуурлын түвшин цар тахлын өмнөх үеэс буурсан гэсэн үр дүнг дэмжиж байна. Өрхийн нийлмэл эмзэг байдлын индексийг 3 бүрэлдэхүүн хэмжигдэхүүнээр задалбал, өрхийн хүн ам зүйн эмзэг байдал бага, харин нийгмийн болон эдийн засгийн эмзэг байдал өндөр байгаа бөгөөд энэ хандлага цар тахлын өмнөх болон дараах үед ижил байна. Гэхдээ цар тахлын дараа өрхийн нийгмийн эмзэг байдал нэмэгдэж, хүн ам зүйн болон эдийн засгийн эмзэг байдал буурсан байна.

Шинжилгээгээр өрхийн хүн ам зүйн шинж байдал цар тахлын өмнө ба дараа ойролцоо байгаа хэдий ч өрхөд байгаа хүүхэд, өндөр настны тоо, насны бүтцээс хамаарч эрүүл мэнд, өвчлөлийн түвшин нэмэгдэх, улмаар зарцуулах үнэлгээгүй хөдөлмөрийн цаг нэмэгдэж охид, эмэгтэйчүүд цагийн ядууралд өртөмтгий болж буйг бусад судалгаанууд нотолсон байна. Цаашилбал, тухайн өрхийн ам бүлийн тоо, өрхийн насны бүтэц зэрэг нь өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдал, хоол тэжээлийн хомсдол, хэрэглээнд нөлөөлж, өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг өсгөх үндэс болох боломжтой юм.

Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад цар тахлын дараах үед өрхийн нийгмийн эмзэг байдал бусад төрлийн эмзэг байдлаас илүү ихээр нэмэгдсэн байна. Өрхийн тэргүүний боловсролын түвшний эмзэг байдал буурсан хэдий ч цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн боловсролын эмзэг байдалд илүү анхаарах нь чухал байна.

Дүн шинжилгээгээр төрөөс тусламж дэмжлэг авдаг байх нь өрхийн нийгмийн эмзэг байдлыг бууруулаагүй байна. Гэхдээ олон хүүхэдтэй болон эмзэг бүлгийн өрхүүдийг гэнэтийн цочролыг даван туулахад энэ нь бодит дэмжлэг болж байна. Цаашилбал, өрхийн нийгмийн сүлжээ муу байх нь эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Ялангуяа, хамаатан садан, найз нөхөд, танилын хүрээлэл муутай, байгууллага, олон нийтийн байгууллагын тусламжаас хүртэж чаддаггүй өрхийн эмзэг байдал өндөр байна. Нийгэм соёлын энэхүү өвөрмөц холбоо, харилцаа нь монголчуудын дунд бодитой оршиж, өрхийн амьжиргаанд тус дэм үзүүлж, эмзэг байдлыг бууруулж байна.

Тогтвортой, найдвартай ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь өрхийн эдийн эмзэг байдлыг бууруулж байгааг шинжилгээний үр дүн нотолж байна. Харамсалтай нь цар тахлын улмаас хувийн хэвшил бараг дангаараа үүрдэг хийгээд эмэгтэйчүүд зонхилон ажилладаг нийтийн үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа зэрэг салбаруудын ажилчид хамгийн их хохирол амссан билээ. Өрх, иргэд хуримтлал, хадгаламжтай байх нь өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг бууруулж байна. Энэ нь хүнсний болон эрүүл мэндийн гэнэтийн цочрол, эрсдэл, эмзэг байдлыг даван туулах чухал нөөц юм. Өрхийн орлого олон төрлийн эх үүсвэртэй байх нь өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг бууруулж чадахгүй байгаа нь өрхүүдийн орлогын хэмжээ болон тогтворгүй байдалтай холбоотой болов уу.

Цар тахлын дараа хотын өрхтэй харьцуулахад хөдөөгийн өрхийн, Улаанбаатартай харьцуулахад бусад бүсийн өрхийн, нийслэл, аймгийн төв, сумын төвтэй харьцуулахад хөдөөгийн багийн өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нийлмэл эмзэг байдал хамгийн ихээр нэмэгдсэн байна. Эмзэг байдал нэмэгдэхийн хэрээр хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн улам бүр нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

Эцэст нь, хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээг нийгмийн анхдагч нэгж болох өрхийн түвшинд хийсэн нь Ковид-19, зуд зэрэг нийтийг хамарсан халдварт цар тахал, байгалийн гамшигт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх оновчтой хариу арга хэмжээ авахад эмпирик нотлох баримтыг бий болгох практик ач холбогдолтой юм. Эмзэг байдал, эрсдэлийн эсрэг богино болон урт хугацааны аливаа хариу арга хэмжээ, дасан зохицох стратеги нь юун түрүүнд өрхийн түвшний чадавхыг бэхжүүлэх, сайжруулах, орон нутгийн засаглалыг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулахад чиглэгдэх ёстой. Ингэснээр айл өрх, олон нийт ирээдүйд аливаа эрсдэл, гамшигт үзэгдлүүдэд илүү тэсвэртэй байх болно.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- Aksha, S., Juran, L., Resler, I., & Y., Z. (2019). *An analysis of social vulnerability to natural hazards in Nepal using a modified social vulnerable index.*
- Cutter, S., Boruff, B., & Shirley, W. (2003). Social vulnerability to environmental hazards. *Soc Sci Quart*, 242-261.
- Ludovico C., Amartuvshin Ts. (2020). *Assessment of the social protection response to COVID-19 in Mongolia.*
- Negusie. (2022). Rural livelihood vulnerabilities, contributing factors and coping strategies in Takusa Woreda, North Western Ethiopia. *Cogent Social Sciences.*
- NSO. (2019). *Time Use Survey 2019.* NSO.
- NSO, WB. (2022). *Mongolia 2020, Poverty report, A decade of progress stagnation in poverty reduction.* Ulaanbaatar.
- Phuong, T., Huynh, A., Thu, T., & Bui. (2024). Household-level demographic and socio-economic vulnerability in the face of the COVID-19 pandemic in rural Central Vietnam. *Research in Globalization.*
- Praveen, K. S., Yarawendra, S., Sandhya, R., Niharika, T., & J, J. (2020). Assessing Socioeconomic Vulnerabilities Related to COVID-19 Risk in India: A State-Level Analysis.
- Sigridur, B., Yue, L., & Mark, G. S. (2011). Social vulnerability index for coastal communities at risk to hurricane hazard and a changing climate. *Natural Hazards*, 1055-1075,.
- Solongo, A. (2020). Internal migration in Mongolia. A. B.-E. Martin Bell-Д, *Internal Migration in the Countries of Asia, A Cross-national Comparison* (хуудсд. 77-91).
- UNDP. (2020). *Rapid Socio-Economic Impact Assessment of COVID-19 Prevention Measures on Vulnerable Groups And Value Chains In Mongolia.*
- UNDP. (2021). *COVID-19 Impact on Women and Girls in Mongolia.*
- UNDP, PTRC. (2004). *Urban Poverty and Migration, survey report.*
- UNICEF, NSO. (2021). *Multiple Indicator Cluster Surveys (MICS) Plus Snapshot – Round IV.*
- Wisner, B. (2013). Assessment of capability and vulnerability. *In mapping vulnerability*, 202-212.
- Yi, L., Zhang, H., Ge, L., & Zhao, D. (2014). Analysis of social vulnerability to hazards in China. *Environmental Earth Sciences*, 3109-3117.

## ХАВСРАЛТ 1.

**Хүснэгт 1А: Өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамгийн их болон хамгийн бага утгууд, 2018 он**

Бүрэлдэхүүн	Үзүүлэлт	Өгөгдлийн тоо	Min	Max
Хүн ам зүйн шинж байдал	Өрхийн тэргүүлэгчийн нас	16,454	17	98
	Амын бүлийн тоо	16,454	1	16
	Өрхийн хүүхэд, өндөр настай гишүүдийн тоо	16,454	0	8
Нийгмийн дэмжлэг	Өрхийн тэргүүний боловсрол	16,454	1	10
	Хамаатай садан, найз нөхдөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	16,454	0	1
	Төрөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	16,454	0	1
	Байгууллага, олон нийт, иргэний нийгмийн байгууллагаас тусламж дэмжлэг авдаг эсэх	16,454	0	1
Эдийн засгийн нөхцөл байдал	Төрийн байгууллагад ажилладаг өрхийн гишүүн байдаг эсэх	16,454	0	1
	Өрх хадгаламж, хуримтлалтай эсэх	16,454	0	1
	Орлогын эх үүсвэрийн тоо	16,454	2	7

**Хавсралт 1Б: Өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамгийн их болон хамгийн бага утгууд, 2022 он**

Бүрэлдэхүүн	Үзүүлэлт	Нэгж	Min	Max
Хүн ам зүйн шинж байдал	Өрхийн тэргүүлэгчийн нас	22,995	16	100
	Амын бүлийн тоо	22,995	1	17
	Өрхийн хүүхэд, өндөр настай гишүүдийн тоо	22,995	0	12
Нийгмийн дэмжлэг	Өрхийн тэргүүний боловсрол	22,995	1	10
	Хамаатай садан, найз нөхдөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	22,995	0	1
	Төрөөс тусламж дэмжлэг авдаг эсэх	22,995	0	1
	Байгууллага, олон нийт, иргэний нийгмийн байгууллагаас тусламж дэмжлэг авдаг эсэх	22,995	0	1
Эдийн засгийн нөхцөл байдал	Төрийн байгууллагад ажилладаг өрхийн гишүүн байдаг эсэх	22,995	0	1
	Өрх хадгаламж, хуримтлалтай эсэх	22,995	0	1
	Орлогын эх үүсвэрийн тоо	22,995	2	7